

Хууль зүйн туслалцааны төвийн
захирлын 2021 оны 14 дугаар
тушаалын хоёрдугаар хэвсрэлт

УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1. Улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 16 дугаар зүйл, Хууль зүйн туслалцааны төвийн дүрмийн "Ес" дэх хэсгийг удирдлага болгон Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Сонгон шалгаруулалтад оролцогчид тавигдах шаардлага

2.1. Улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтад оролцогч нь дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, шүүхэд төлөөлөх эрх бүхий хуульч байна.

2.2. Хуульчийн гэрчилгээ, шүүхэд төлөөлөх эрх, өмгөөллийн эрх авсан байх /Ажлын хэсэг холбогдох материалын лавлагааг МӨХ-оос авна/;

2.3. Монголын Хуульчдын холбооны гишүүний татвар, хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдсан, кредит цагийн тооцоогүй тодорхойлолтыг авсан байх.

2.4. Шалгаруулалтад орох хуульч нь дор дурдсан бичиг баримтыг сонгон шалгаруулалт зарласан хугацаанд бүрдүүлэн Хууль зүйн туслалцааны төвд цахимаар өгч бүртгүүлсэн байна. Үүнд:

- 2.4.1. Сонгон шалгаруулалтад оролцогчийн анкет;
- 2.4.2. Төрийн албан хаагчийн анкет;
- 2.4.3. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар;
- 2.4.4. Шүүхэд төлөөлөх эрхийн үнэмлэхийн хуулбар;
- 2.4.5. Дээд боловсролын дипломын хуулбар;
- 2.4.6. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
- 2.4.7. Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 2.4.8. Ажиллах хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл.

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэх

3.1. Энэхүү удирдамжийн 3.2-т зааснаас бусад тохиолдолд өргөдөл гаргагчид шалгалтад орох эрх олгож, шалгаруулалтад бүртгүүлсэн иргэдэд утсаар болон оролцогчийн и-мэйл хаягаар мэдэгдэж бүртгэнэ.

3.2. Ажлын хэсэг дор дурдсан үндэслэлээр сонгон шалгаруулалтад бүртгэхээс татгалзана:

- 3.2.1. энэ удирдамжийн "Хоёр" дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;
- 3.2.2. энэ удирдамжийн 2.4-т заасан баримт бичгийг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн;
- 3.2.3. сонгон шалгаруулалтад оролцохоос өөрөө татгалзсан.

Дөрөв. Шалгалтын хамрах хүрээ, хугацаа

4.1. Сонгон шалгаруулалтыг бичгийн болон ярилцлагын хэлбэрээр явуулах бөгөөд оролцогч тус бүр дээр шалгаруулалтын явцыг тодорхой тэмдэглэл хөтөлнө. Шалгаруулалтад дараахь үзүүлэлтийг үндэслэл болгоно. Үүнд:

4.1.1. Хууль хэрэглээ

Ач холбогдол: Улсын өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахдаа хуулийг зөв хэрэглэж, үндэслэл бүхий тайлбар хийх нь гэмт хэргийг зөв зүйлчлэх, оногдуулах ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, гэм буруугүйд тооцуулахад чухал нөлөөтэй.

4.1.2. Логик сэтгэлгээ;

Ач холбогдол: Тохиолдол, өгөгдөлүүдийг дэс дараалалд оруулан эмхлэн цэгцлэх, задлан шинжлэх замаар мэдээлэл олж авах; аливаад нухацтай хандаж, нягтлан шалгах, эргэлзэх замаар алдаа дутагдлыг илрүүлэх, эргэцүүлж бодон дүгнэлт гаргахад ач холбогдолтой.

4.1.3. Ярих ур чадвар;

Ач холбогдол: Сонгон шалгаруулалтад оролцогчийг хувь хүн талаас нь дүгнэх, яагаад улсын өмгөөлөгчөөр ажиллах хүсэлтэй байгаа, ирээдүйд улсын өмгөөлөгчийн нэр хүндийг дээшлүүлэхэд нөлөөлж чадахуйц хүн мөн эсэх, төлбөрийн чадваргүй яллагчдагчийн эрхийг хангаж ажиллах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэх эсэхийг дүгнэхэд ач холбогдолтой.

4.2. Сонгон шалгаруулалтын хугацааг дараах байдлаар зохион байгуулна:

4.2.1. Бичгийн шалгалтын үргэлжлэх хугацаа 120 минут;

4.2.2. Ярилцлагын шалгалтын үргэлжлэх хугацаа шалгалтад оролцогч тус бүрт 5 минут байна.

4.3. Шалгаруулалтад тухайн салбарт улсын өмгөөлөгчөөр ажилд орохоор 1 хуульч бүртгүүлсэн тохиолдолд түүнээс энэхүү удирдамжийн 4.1, 4.2-т заасны дагуу шалгалт авч, дүгнэлтийг ажлын хэсэг гаргана.

Тав. Шалгалтын үнэлгээ

5.1. Шалгалтын нийт оноо 100 оноо байх бөгөөд бичгийн шалгалт 60 оноо, ярилцлагын шалгалт 40 оноо байна.

5.2. Бичгийн шалгалтад дараах байдлаар үнэлгээ өгнө:

5.2.1. Зөв бичих, найруулга зүй 20 оноо

5.2.2. Хууль хэрэглээ 20 оноо

5.2.3. Логик сэтгэлгээ 20 оноо

5.3. Шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан хуульчийг уг албан тушаалд тэнцсэнд тооцох бөгөөд улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүдийн нийт үнэлгээний дунджаар гаргана.

Зургаа. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хэлбэр

6.1. Нийслэл дэх салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтыг танхимаар зохион байгуулна.

6.2. Улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулах ажлыг 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 11.00 цагт Хууль зүйн туслалцааны төвийн байр /Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо Бага тойруу-49, Мэдээлэл технологийн Үндэсний паркийн байр 4 давхар/-ны хурлын танхимд зохион байгуулна.

6.3. Орон нутаг дахь салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтыг Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос авч

хэрэгжүүлж буй хорио цээрийн дэглэмтэй холбогдуулан цахимаар зохион байгуулна. Цахимаар дараах хэлбэрээр зохион байгуулна:

6.3.1.Ажлын хэсгээс цахимаар сонгон шалгаруулалтад оролцогчдод "Google meeting" програмын нэвтрэх нэр, нууц үгийг хүргүүлнэ.

6.3.2.Улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтыг 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 11.00 цагт эхэлнэ.

6.3.3.Бичгийн шалгалтын үргэлжлэх хугацаа 120 минут дуусмагц 10 минутын дотор Хууль зүйн туслалцааны төвийн info@lac.gov.mn цахим хаягт илгээнэ. Заасан хугацаанд илгээгээгүй тохиолдолд материалыг хүлээн авахгүй.

6.3.4.Ярилцлагын шалгалтын цагийг оролцогчдод тухайн үед нь мэдэгдэнэ.

6.3.5.Сонгон шалгаруулалтад цахимаар оролцоход техник, тоног төхөөрөмж, интернэт, компьютерийн саадгүй ажиллагааг оролцогч өөрөө хариуцна.

6.4.Сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагыг хангасан оролцогчдод сонгон шалгаруулалтыг зохион байгуулах өдрөөс 2 хоногийн өмнө товыг мэдэгдэнэ.

Зургаа. Сонгон шалгаруулалттай холбогдуулан гомдол гаргах

6.1.Өргөдөл гаргагч нь шалгалтад оруулахаас татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шалгалт эхлэхээс өмнө 2 хоногийн өмнө Хууль зүйн туслалцааны төвийн захиралд гомдол гаргаж болно.

6.2.Сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг шалгалт дууссан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан комисст гаргана.